



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД:СНАГ-2025/152/НА-СТА-ТШ3

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: В.Эрдэнэцогт
Утас: 261815 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
Аудитор: Ж.Бямбацигт
Утас: 261815 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эс Жи Эм Ди-Аудит ХХК
Захирал: Д.Эхбаяр
Утас: 99116948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	16
4. Аудитын тайлан	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрлын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	24
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. Аудитын илрүүлэлт.....	25
5.1 Албан шаардлага	25
5.2 Зөвлөмж	26
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРАЛ ЖОТГОНБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025. 02. 25 № 07/673
танай -ны № -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлзэ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бусаар, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуванс хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс шилжүүлсэн гадаад сургалтын төлбөр 109,304.3 мянган төгрөгийг орлогоор бүртгэж тайлагнасан, эрх бүхий төсвийн захирагчийн шийдвэр байхгүй;
- НҮБ-ийн Хүн амын сангийн хөрөнгө оруулалтаар "Зүрх судасны мэс заслын тасгийн хагалгааны өрөөнүүдийг вакум нээлттэй мэс заслын өрөө болгон засварлах" тендерт ерөнхий шаардлага хангаагүй "Би Эм Си Эм" ХХК-ийг шалгаруулан гэрээ байгуулсан, засварын ажлыг гэрээнд заасан хугацаанд дуусаагүй, гэрээг сунгасан;
- Тайлант хугацаанд хог хаягдлын төлбөрт 32,960.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд бараа ажил үйлчилгээ нийлүүлэх сонгон шалгаруулалт явуулаагүй;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д заасны дагуу 140,400.0 мянган төгрөгийн 2 худалдан авалтыг 3 багцаар шууд худалдан авалт хийсэн боловч энэ нь хуульд заасны дагуу хэрэгжээгүй. Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаас 36,094.8 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан;

зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.9, 35 дугаар зүйлийн 35.1.1 заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны эцсээр төлбөртэй үйлчилгээний авлага 1,660,363.3 мянган төгрөг, байгууллагад төлөх эмийн өглөг нь 9,044,061.9 мянган төгрөг байгаа нь эмийн өглөгүүдийг төлөх боломжгүй байдал үүсэх, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учир болзошгүй байна.

Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн Нөхөн үржихүйн зөвлөх поликлиникийн өргөтгөл "Перинатологийн клиник"-ийн 4 давхар шинэ барилга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6,445,799.7 мянган төгрөгөөр баригдаж 2024 оны 5 дугаар сард улсын комиссын дүгнэлтээр ашиглалтад орсон.

Тайлант онд хүүхдийн яаралтай тусламжийн тасаг, хоол боловсруулах эмгэгийн тасаг, мэс заслын эрчимт эмчилгээний тасаг, Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн төрсний дараах тасаг, эрсдэлтэй жирэмсэн судлалын тасаг, дутуу тээлт судлалын тасаг, нярай судлалын тасгуудын барилгын их засварын ажил мянган төгрөгөөр хийгдэж, техникийн комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хүүхдийн эмнэлгийн зүрхний мэс заслын 2 баг 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, 20 хүүхдийн 24 нүдэнд торлог шилэнцирийн мэс заслыг, ухархайн хугарллын нөхөн сэргээх мэс заслыг 10 хүүхдэд тус тус амжилттай хийсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Дутуу нярайн уушги гэмтэхээс сэргийлэх өндөр давтамжит аргаар (HFO) амьсгалуулах эмчилгээг Нярайн эрчимт эмчилгээний тасагт бүрэн нэвтрүүлсэн.

Хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг тусламж, үйлчилгээнд 2014 оноос нэвтрүүлж, 10 жилийн хугацаанд нийт 9 хүүхдэд элэг шилжүүлэн суулгах мэс заслыг эх орондоо амжилттай хийгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТИН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР 

Ц. НАРАНЧИМЭГ

Д.Адуулж 2025109
9023030583

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,896,391,989.01	9,148,856,298.75
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	515,592,896.23	3,110,881,900.15
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	515,592,896.23	3,110,881,900.15
3121	Төгрөг	515,592,896.23	3,110,881,900.15
31211	Төрийн сангийн харилцах	515,577,451.08	3,110,868,255.00
31213	Арилжааны банк дахь харилцах	15,445.15	13,645.15
33	АВЛАГА	5,977,135,411.50	2,049,121,710.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	19,053,716.50	21,678,406.50
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,805,069,397.00	1,660,363,355.65
335	Бусад авлага	153,012,298.00	367,079,948.67
3351	Байгууллагаас авах авлага	153,012,298.00	367,079,948.67
34	УРЬДЧИЛГАА	-	0.04
34600	Урьдчилж гарсан зардал	-	0.04
35	БАРАА МАТЕРИАЛ	4,403,663,681.28	3,988,852,687.74
351	Түүхий эд материал	1,225,596,679.60	1,111,588,619.13
35130	Эм боох материал	1,225,596,679.60	1,111,588,619.13
354	Хангамжийн материал	3,178,067,001.68	2,877,264,068.61
35410	Бичиг хэргийн материал	9,155,826.00	7,923,165.00
35420	Аж ахуйн материал	47,065,039.85	62,558,011.80
35430	Сэлбэг хэрэгсэл	23,674,473.44	11,368,075.00
35440	Түлш, шатах тослох материал	7,680,000.00	3,540,000.00
35460	Хүнсний материал	81,347,435.00	15,699,659.00
35470	Бусад хангамжийн материал	3,009,144,227.39	2,776,175,157.81
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	65,137,813,357.17	71,764,133,331.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	65,137,813,357.17	71,764,133,331.31
392	Биет хөрөнгө	58,933,124,857.17	65,546,092,538.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	49,769,707,673.16	60,837,327,452.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,146,957,067.64)	(10,116,819,900.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	537,270,521.00	1,229,739,112.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(423,607,413.44)	(511,552,507.94)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53,651,759,535.07	55,975,649,001.21
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,398,791,256.56)	(42,754,340,157.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,615,104,743.73	2,662,825,059.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,680,666,428.15)	(1,797,540,071.94)
39214	Бусад үндсэн хөрөнгө	568,544,247.56	566,713,294.62
39215	Хуримтлагдсан элэгдэл	(568,544,247.56)	(566,713,294.62)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	9,304,550.00	20,804,550.00
393	Биет бус хөрөнгө	6,204,688,500.00	6,218,040,792.97
39301	Програм хангамж	287,613,849.48	301,753,849.48
39302	Хуримтлагдсан элэгдэл	(287,613,849.48)	(288,401,556.51)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,204,688,500.00	6,204,688,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	76,034,205,346.18	80,912,989,630.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,913,027,895.00	10,201,065,444.85

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,913,027,895.00	10,201,065,444.85
413	Өглөг	4,913,027,895.00	10,101,065,444.85
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	537,898.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	59,600,380.00	1,056,465,610.00
4136	Бусад өглөг	4,853,427,515.00	9,044,061,936.85
41361	Байгууллагад төлөх өглөг	4,853,427,515.00	9,044,061,936.85
414	Урьдчилж орсон орлого	-	100,000,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	100,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	71,121,177,451.18	70,711,924,185.21
51	Засгийн газрын хувь оролцоо	71,121,177,451.18	70,711,924,185.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	19,625,186,499.80	19,625,186,499.80
51101	Өмч:- төрийн	19,625,186,499.80	19,625,186,499.80
512	Хуримтлагдсан үр дүн	21,857,867,915.50	21,448,614,649.53
51210	Өмнөх үеийн үр дүн	22,916,971,143.15	21,857,867,915.50
51220	Тайлант үеийн үр дүн	(1,059,103,227.65)	(409,253,265.97)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	29,638,123,035.88	29,638,123,035.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	76,034,205,346.18	80,912,989,630.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	61,439,809,495.23	69,575,628,152.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,074,561,160.29	20,117,931,865.97
120	Нийтлэг татварын бус орлого	1,781,957,781.96	1,752,101,318.37
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,781,957,781.96	1,752,101,318.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	903,326,828.00	1,194,968,867.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	227,236,473.00	214,081,977.98
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	651,394,480.96	343,050,473.29
122	Тусламжийн орлого	13,292,603,378.33	18,365,830,547.60
122001	Хандив тусламж /дотоод/	13,292,603,378.33	18,365,830,547.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,365,248,334.94	49,457,696,286.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	982,824,777.94	1,148,079,846.90
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	982,824,777.94	1,148,079,846.90
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	45,382,423,557.00	48,309,616,439.49
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,256,371,857.00	-
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	10,126,051,700.00	48,309,616,439.49
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	62,498,593,866.18	69,984,862,312.23
21	ҮРСГАЛ ЗАРДАЛ	62,498,593,866.18	69,984,862,312.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,003,703,364.18	68,982,773,097.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,159,590,103.72	34,983,817,803.94
210101	Үндсэн цалин	17,185,947,612.62	19,474,364,320.11
210102	Нэмэгдэл	10,616,355,169.10	11,830,966,163.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,075,705,000.00	1,100,800,000.00
210104	Урамшуулал	2,281,582,322.00	2,577,687,320.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,904,640,964.00	4,382,501,079.00
210201	Тэтгэврийн даатгал	2,738,603,863.00	2,939,514,330.00
210202	Тэтгэмжийн даатгал	308,091,863.00	460,829,070.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	246,473,778.00	217,879,812.00
210204	Ажилгүйдлийн даатгал	55,361,436.00	152,278,881.00
210205	Эрүүл мэндийн даатгал	556,110,024.00	611,998,986.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,807,498,016.34	1,986,585,488.56
210301	Гэрэл, цахилгаан	801,320,209.12	830,058,212.31
210302	Түлш, халаалт	539,492,636.54	484,386,790.24
210303	Цэвэр, бохир ус	466,685,170.68	672,140,486.01
2104	Хангамж, бараа материалын зардал	817,178,884.49	785,132,614.96
210401	Бичиг хэрэг	157,954,809.45	107,053,947.02
210402	Тээвэр, шатахуун	45,320,088.52	54,210,817.89
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,633,336.60	25,539,632.03

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	519,158,883.26	555,078,984.09
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,111,766.66	43,249,233.93
2105	Нормативт зардал	15,429,121,690.63	18,106,902,459.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,713,414,063.40	16,088,687,662.23
210502	Хоол, хүнс	1,442,972,957.60	1,610,791,480.12
210503	Нормын хувцас, зөвлөн эдлэл	272,734,669.63	407,423,317.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	799,986,394.95	317,188,803.75
210601	Багаж, техник, хэрэгсэл	148,449,898.84	29,819,971.45
210604	Урсгал засвар	651,536,496.11	287,368,832.30
2107	Томилолт, зочны зардал	285,922,691.62	310,225,411.44
210701	Гадаад албан томилолт	-	133,639,800.00
210702	Дотоод албан томилолт	285,922,691.62	176,585,611.44
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,572,907.00	189,565,758.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,832,682.00	133,350,540.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,300,000.00	16,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,732,202.00	3,438,049.96
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	308,000.00	308,000.00
210807	Газрын төлбөр	16,325,417.00	16,325,417.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	74,606.00	40,465.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	19,603,286.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,721,191,711.43	7,920,853,678.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	193,691,380.83	160,996,489.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,120,600.00	819,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,476,379,730.60	7,759,038,188.59
213	ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,494,890,502.00	1,002,089,214.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,494,890,502.00	1,002,089,214.33
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,321,767,414.00	938,865,629.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	173,123,088.00	63,223,585.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,058,784,370.95)	(409,234,159.87)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	318,856.70	19,106.10
225001	Үндсэн хөрөнгө худалсаны гарз	318,856.70	19,106.10
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(318,856.70)	(19,106.10)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,059,103,227.65)	(409,253,265.97)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	48,898,395,139.55	59,824,507,355.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,131,541,314.98	1,573,902,905.08
120	Нийтлэг татварын бус орлого	1,131,541,314.98	1,573,902,905.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,131,541,314.98	1,573,902,905.08
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	903,326,828.00	1,232,014,801.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	228,214,486.98	341,888,103.98
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	47,766,853,824.57	58,250,604,450.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,589,499,664.57	5,796,281,970.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчтэй бус этгээдээс авсан хандив, тусламж	-	100,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,589,499,664.57	5,696,281,970.50
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	44,177,354,160.00	52,454,322,480.35
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	44,177,354,160.00	52,454,322,480.35
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	50,754,557,699.46	56,736,719,459.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,754,557,699.46	56,736,719,459.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,249,968,965.46	55,728,010,244.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,356,072,757.44	35,868,837,926.79
210101	Үндсэн цалин	13,410,419,559.77	17,990,383,685.91
210102	Нэмэгдэл	12,277,729,335.51	14,374,475,006.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,069,289,832.65	1,096,165,396.63
210104	Урамшуулал	2,598,634,029.51	2,407,813,837.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,493,467,005.35	4,986,946,118.87
210201	Тэтгэврийн даатгал	2,448,245,673.08	3,769,063,329.18
210202	Тэтгэмжийн даатгал	258,338,491.92	399,357,950.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	219,045,079.76	169,637,469.64
210204	Ажилгүйдлийн даатгал	53,175,709.68	171,003,557.99
210205	Эрүүл мэндийн даатгал	514,662,050.91	477,883,811.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,835,141,867.62	1,977,563,206.28
210301	Гэрэл, цахилгаан	802,518,636.41	841,999,619.31
210302	Түлш, халаалт	498,945,087.53	536,577,222.56
210303	Цэвэр, бохир ус	533,678,143.68	598,986,364.41
2104	Хангамж, бараа материалын зардал	693,795,698.60	589,619,555.03
210401	Бичиг хэрэг	75,659,918.00	53,390,992.00
210402	Тээвэр, шатахуун	47,100,000.00	45,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,433,336.60	28,390,732.03
210405	Хог хаягдал зайлзулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	441,641,221.00	343,848,427.00

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	106,961,223.00	118,989,404.00
2105	Нормативт зардал	12,645,611,562.15	10,957,301,070.21
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,763,494,257.15	9,961,998,641.21
210502	Хоол, хүнс	1,495,251,960.00	948,703,929.00
210503	Нормын хувцас, зөвлөн эдлэл	386,865,345.00	46,598,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	402,448,009.00	669,346,448.17
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,325,485.00	444,616,979.17
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,840,000.00	21,621,000.00
210604	Урсгал засвар	356,282,524.00	203,108,469.00
2107	Томилолт, зочны зардал	268,186,166.30	310,544,238.00
210701	Гадаад албан томилолт	-	144,453,600.00
210702	Дотоод албан томилолт	268,186,166.30	166,090,638.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,205,684.00	193,641,872.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,326,617.00	151,498,610.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	13,300,000.00	16,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,495,220.00	2,206,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,236,982.00	1,147,430.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	308,000.00	308,000.00
210807	Газрын төлбөр	16,325,417.00	16,325,417.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	71,948.00	47,265.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	33,141,500.00	5,609,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	395,040,215.00	174,209,809.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	333,910,415.00	171,753,809.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,129,800.00	2,456,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,504,588,734.00	1,008,709,214.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,504,588,734.00	1,008,709,214.33
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,321,767,414.00	938,865,629.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалт	182,821,320.00	69,843,585.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(1,856,162,559.91)	3,087,787,896.75
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,419,259,735.00	492,498,892.83
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,419,259,735.00	492,498,892.83
2200	Дотоод эх үүсвэрээр	1,419,259,735.00	492,498,892.83
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,419,259,735.00	492,498,892.83
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,419,259,735.00)	(492,498,892.83)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(3,275,422,294.91)	2,595,289,003.92
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,791,015,191.14	515,592,896.23
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	515,592,896.23	3,110,881,900.15

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	22,916,971,143.15	72,180,280,678.83
3	Дахин илэрхийлсэ н үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	22,916,971,143.15	72,180,280,678.83
7	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,059,103,227.65)	(1,059,103,227.65)
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	21,857,867,915.50	71,121,177,451.18
11	Дахин илэрхийлсэ н үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	21,857,867,915.50	71,121,177,451.18
16	Тайлант үеийн үр дүн	-	-	(409,253,265.97)	(409,253,265.97)
17	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	19,625,186,499.80	29,638,123,035.88	21,448,614,649.53	70,711,924,185.21

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,246,444,700.00	57,229,218,352.01	7,017,226,347.99	89.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,246,444,700.00	57,229,218,352.01	7,017,226,347.99	89.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	64,246,444,700.00	56,220,509,137.68	8,025,935,562.32	87.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,712,135,300.00	35,868,837,926.79	3,843,297,373.21	90.3
210101	Үндсэн цалин	17,616,070,000.00	17,990,383,685.91	(374,313,685.91)	102.1
210102	Нэмэгдэл	17,668,994,200.00	14,374,475,006.58	3,294,519,193.42	81.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,789,497,100.00	1,096,165,396.63	693,331,703.37	61.3
210104	Урамшуулал	2,637,574,000.00	2,407,813,837.67	229,760,162.33	91.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,457,088,900.00	4,986,946,118.87	470,142,781.13	91.4
210201	Тэтгэврийн даатгал	3,703,937,500.00	3,769,063,329.18	(65,125,829.18)	101.8
210202	Тэтгэмжийн даатгал	642,831,800.00	399,357,950.13	243,473,849.87	62.1
210203	ҮОМШ-ний даатгал	151,720,000.00	169,637,469.64	(17,917,469.64)	111.8
210204	Ажилгүйдлийн даатгал	151,720,000.00	171,003,557.99	(19,283,557.99)	112.7
210205	Эрүүл мэндийн даатгал	806,879,600.00	477,883,811.93	328,995,788.07	59.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,998,503,300.00	1,977,563,206.28	20,940,093.72	99.0
210301	Гэрэл, цахилгаан	935,344,600.00	841,999,619.31	93,344,980.69	90.0
210302	Түлш, халаалт	518,158,700.00	536,577,222.56	(18,418,522.56)	103.6
210303	Цэвэр, бохир ус	545,000,000.00	598,986,364.41	(53,986,364.41)	109.9
2104	Хангамж, бараа материалын зардал	563,880,200.00	605,251,555.03	(41,371,355.03)	107.3
210401	Бичиг хэрэг	68,805,200.00	53,390,992.00	15,414,208.00	77.6
210402	Тээвэр, шатахуун	41,250,000.00	45,000,000.00	(3,750,000.00)	109.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,000,000.00	28,390,732.03	(8,390,732.03)	142.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	333,847,700.00	343,848,427.00	(10,000,727.00)	103.0
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	99,977,300.00	134,621,404.00	(34,644,104.00)	134.7
2105	Нормативт зардал	12,460,937,800.00	10,957,301,070.21	1,503,636,729.79	87.9

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,432,283,400.00	9,961,998,641.21	1,470,284,758.79	87.1
210502	Хоол, хүнс	981,158,800.00	948,703,929.00	32,454,871.00	96.7
210503	Нормын хувцас, зөвлөн эдлэл	47,495,600.00	46,598,500.00	897,100.00	98.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,620,825,800.00	1,146,213,341.00	474,612,459.00	70.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,358,491,800.00	915,321,122.00	443,170,678.00	67.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	74,999,700.00	21,621,000.00	53,378,700.00	28.8
210604	Ургал засвар	187,333,300.00	209,271,219.00	(21,937,919.00)	111.7
2107	Томилолт, зочны зардал	625,754,600.00	310,544,238.00	315,210,362.00	49.6
210701	Гадаад албан томилолт	364,589,000.00	144,453,600.00	220,135,400.00	39.6
210702	Дотоод албан томилолт	261,165,600.00	166,090,638.00	95,074,962.00	63.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,294,500.00	193,641,872.00	(29,347,372.00)	117.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,192,700.00	151,498,610.00	(68,305,910.00)	182.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,500,000.00	16,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,500,000.00	2,206,150.00	1,293,850.00	63.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,733,600.00	1,147,430.00	586,170.00	66.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	500,000.00	308,000.00	192,000.00	61.6
210807	Газрын төлбөр	16,636,300.00	16,325,417.00	310,883.00	98.1
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	47,265.00	252,735.00	15.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	41,931,900.00	5,609,000.00	36,322,900.00	13.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	689,789,200.00	174,209,809.50	515,579,390.50	25.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	542,997,700.00	171,753,809.50	371,243,890.50	31.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	146,791,500.00	2,456,000.00	144,335,500.00	1.7

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	953,235,100.00	1,008,709,214.33	(55,474,114.33)	105.8
2132	Бусад ургал шилжүүлэг	953,235,100.00	1,008,709,214.33	(55,474,114.33)	105.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	903,235,100.00	938,865,629.33	(35,630,529.33)	103.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000,000.00	69,843,585.00	(19,843,585.00)	139.7
	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,246,444,700.00	59,824,507,355.93	4,421,937,344.07	93.1
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨЕС САНХҮҮЖИХ	57,621,880,900.00	52,454,322,480.35	5,167,558,419.65	91.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	57,621,880,900.00	52,454,322,480.35	5,167,558,419.65	91.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНА АС	6,624,563,800.00	7,370,184,875.58	(745,621,075.58)	111.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	837,207,600.00	1,232,014,801.10	(394,807,201.10)	147.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,735,969,200.00	341,888,103.98	5,394,081,096.02	6.0
1200044	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	50,387,600.00	5,796,281,970.50	(5,745,894,370.50)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,110,881,900.15	(3,110,881,900.15)	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				0.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАД ҮИН ТОО	1047	998	49	95.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	775	670	105	86.5
620003	Үйлчлэх ажилтан	272	327	55	120.2

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв эмнэлгийн эрхэм зорилгоо “эх, хүүхдэд төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг эмнэл зүйн сургалт, эрдэм шинжилгээний нэгдэлд тулгуурлан, чанартай хүртээмжтэйгээр үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйлчилгээ үзүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилтын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол хүний эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтвортой хөгжлийн зорилт, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын хэрэгжилтийг хангах;
- Эрүүл мэндийн салбарын удирдлагын чадавхыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг нийт хүн амд хүргэх, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээг чанаржуулах, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, чадавхыг бэхжүүлэх;
- Яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, сайд, Засгийн газрын танхимд үзүүлэх зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэгийг мэргэшлийн өндөр түвшинд хүргэх;

Тайлант оны онцлох үйл явдал:

- Хүүхдэд тархи, мэдрэлийн төрөлжсөн мэс заслын тусlamжийг тус эмнэлэгт нэвтрүүлэхээр ажиллаж байна. 11 дүгээр сарын байдлаар 8 хүүхдэд тархи усжилтын үеийн шунт тавих мэс засал, 1 хүүхдэд тархины буглааны мэс засал, 4 хүүхдэд нугасны ивэрхийн мэс заслыг буюу нийт 13 хүүхдэд мэдрэлийн мэс заслыг тус тус амжилттай хийгээд байна.
- “Хүүхдийн бамбай булчирхайн эдийн шинжилгээ” хийх эмнэл зүйн заавар батлуулж, эхо хяналт дор хатгалтын биопси хийх шинэ технологийг эмнэл зүйн практикийг эхлүүлсэн.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь Эрүүл мэндийн тухай хууль Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Тухайлбал:

- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Шилэн дансны тухай хуульд өөрчлөлт;
- Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт;

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өргтгийн дээд хязгаар тогтоох тухай” шинээр баталсан;
- Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-д өөрчлөлт оруулсан;
- Засгийн газрын 2024 оны 171 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-д өөрчлөлт оруулсан;
- ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам” шинэчлэн баталсан;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Эрүүл мэндийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,878,784.3 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	515,592.9	3,110,881.9	2,595,289.0
Авлага	5,977,135.4	2,049,121.7	(3,928,013.7)
Бараа материал	4,403,663.7	3,988,852.7	(414,811.0)
Үндсэн хөрөнгө	65,137,813.4	71,764,133.3	6,626,320.0
Нийт хөрөнгө	76,034,205.3	80,912,989.6	4,878,784.3
Өр төлбөр	4,913,027.9	10,201,065.4	5,288,037.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	71,121,177.5	70,711,924.2	(409,253.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	76,034,205.3	80,912,989.6	4,878,784.3

Тайлант онд нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын хувь оролцоо данстууд байна. Үүнд :

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,110,868.2 мянган төгрөг болж 2,595,290.8 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах төлбөртэй үйлчилгээний орлого оны гүйлгээний сүүлийн өдөр орж ирсэнтэй холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл 2,049,121.7 мянган төгрөг болж 3,928,013.7 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах өмнөх оны авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. Авлагын дансанд эрүүл мэндийн даатгалын сангаас авах төлбөртэй үйлчилгээний авлага 1,660,363.3 мянган төгрөг, ажиллагсдаас авах 21,678.4 мянган төгрөг, бусад авлага 367,079.9 мянган төгрөгийн авлагыг тус тус бүртгэлтэй байна.
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 414,811.0 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар буурахад худалдан авсан 18,106,830.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 16,495,553.5 мянган төгрөг, эмнэлгийн захирлын 2024 оны тушаалын дагуу акталж, устгасан 19,677,318.7 мянган төгрөгөөр хасагдсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгийн данс тайлант онд худалдан авсан 492,498.9 мянган төгрөг, ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар баригдсан барилга, байгууламж, тоног төхөөрөмж 10,922,342.4 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2024 оны 495, 808 дугаар тогтоолуудын дагуу элэгдлээрээ анхны өртөө нөхсөн хөрөнгийг данс бүртгэлээс хассан 229,870.06 мянган төгрөгөөр хасагдсан байна.
- Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх өр төлбөр өмнөх оноос 5,288,037.5 мянган төгрөгөөр буюу 107.6 хувиар өссөн нь өр төлбөр дансны үлдэгдэлд эм ханган нийлүүлэх байгууллагад өглөг 8,244,682.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 1,855,845.3 мянган төгрөг, ажиллагсадтай холбогдсон өглөг 537.8 мянган төгрөг, урьдчилж орсон орлого 100,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой юм.
- Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 70,711,924.1 мянган төгрөг болж өмнөх оноос 409,253.3 мянган төгрөгөөр буюу 0.6 хувиар буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус эмнэлгийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 52,526,410.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 888,926.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 564,131.3 мянган төгрөг бүрдүүлэхээр, нийт орлого, зарлагыг 53,979,468.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг хянан, бараа үйлчилгээний зардлыг 1,493,912.5 мянган төгрөгөөр бууруулж 53,950,673.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2024 оны 2 дугаар улиралд Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлснээс, шалтгаалсан байна. Тайлант оны эхэнд батлагдсан төсвийг 35,561.3 сая төгрөгөөр бууруулж шинэчлэн тодотгожээ.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 52,526,410.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,453,057.7 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос бүрдүүлж, өмнөх оны үлдэгдлээс 311,772.2 мянган төгрөгийг зарцуулахаар байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 45,167,006.6 мянган төгрөг буюу 83.6 хувтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардлыг 769.0 мянган төгрөг, байр ашиглалтын тогтмол зардлыг 20,940.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 105.5 мянган төгрөг, норматив зардлыг 1,138,763.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний, төлбөр хураамжийн зардлыг 33,776.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний Нэр		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код					
1	71602	Эмнэлгийн тусlamж үйлчилгээ	68,433,209.60	57,229,216.44	(11,203,993.16)	83.6%
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	53,950,673.80	45,097,163.02	(8,853,510.78)	83.6%
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, шагнал урамшуулал	72,000.00	69,843.58	(2,156.42)	97.0%
1.3	83601	Нэмэлт - Олон улсын байгууллагаас олгосон	1,108,451.60	1,102,734.90	(5,716.70)	99.5%
1.4	83603	Нэмэлт - Дээд шатны төсвиеөс хуваарилсан	13,302,084.20	10,959,474.94	(2,342,609.26)	82.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 15,729,610.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 16 бараа, ажил, үйлчилгээг, үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 5, харьцуулалтын аргаар 11 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж баталсан байна.

Гүйцэтгэлээр ХАА-ны төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтаар 14,670,661.01 мянган төгрөг, цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр 2,429,267.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланда аудит хийсэн эмнэлэг, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эс Жи Эм Ди-Аудит ХХК-ийн ахлах аудитор О.Алтанцэцэг, аудитор О.Ганчимэг, аудитын шинжээч Ч.Ням-Очир, туслах ажилтан Э.Есүхэй нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Б.Оюунцэцэг, аудитын менежер Д.Насанжаргал, захирал Д.Эхбаяр нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 52 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, 1.5 хувиар буюу 937,478.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоо шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэн бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх, цалин хөлсийг ажлын гүйцэтгэл, үр дүнтэй нь уялдуулан олгосон, байгууллагаас хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй, сургалт, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 4 зөвлөмж хүргүүллээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтооолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 288 удаагийн 119,076,265.7 мянган төгрөгийн мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэллээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Эмнэлгийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд тус эмнэлгийн хамт олны төлөөлөх 3 гишүүнийг томилуулахаар Ерөнхий захирлын тушаал гаргаагүй бөгөөд "Ажлын хэсэг байгуулах тухай" гишүүдийг сонгох хурал хийгээгүй байна. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д "Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ", 17.7-д "Төрийн болон орон нутгийн өмчийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүнтэй байна." гэсэн заалттай нийцээгүй.
Шийдвэрлэсэн нь:

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг сонгох ажиллагааг явуулж, эрх бүхий байгууллагуудаас томилох гишүүдийг томилуулах хүсэлтийг хүргүүлэх, ТУЗ-ийн чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зөвлөмж өгөв.

2. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь санхүүгийн дотоод хяналтын ажилтангүй бөгөөд тайлант хугацаанд санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" Засгийн газрын 311 дугаар тогтоолын 4.1.5-д "Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл

ажиллагаанд тавих хяналт шалгалт", Төсвийн тухай хуулийн 16.5.6 "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх". Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоолын хавсралт Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 3.3 "Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь:

ТҮЗ-ийн бүрэлдэхүүнийг сонгох ажиллагааг явуулж, эрх бүхий байгууллагуудаас томилох гишүүдийг томилуулах хүсэлтийг хүргүүлэх, чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зөвлөмж өгөв.

3. Тус эмнэлгийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар холбогдох хуулиудыг хэрэгжүүлээгүй, цахим хаяг ашиглахгүй, мэдээллийн аюулгүй байдал хэрхэн хангаж байгаа нь тодорхой бус байна. Энэ нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 "Кибер орчинд дундын мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл боловсруулах, хадгалах, түгээх, цахим тооцооллын болон түүний хэвийн үйл ажиллагааг хангахад мэдээллийн технологийн чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд дараах үүргийг хүлээнэ", 19 дүгээр зүйлийн 19.1 "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагад дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага хамаарна:" 19.1.3 "Хоёр, гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллага" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Эмнэлэгт кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журам батлах, цахим хаяг ашиглах, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийх, холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах зэрэг шаардлагуудыг хэрэгжүүлэх зөвлөмжийг өгөв.

4. Тус эмнэлэг нь хүний нөөцийн чиглэлээр үйл ажиллагааны онцлогт тохирсон орон тоог зохистойгоор бүрдүүлээгүй, сувилагчийн орон тоо дутагдалтай байгаа нь эрүүл мэндийн туссламж, үйлчилгээг чанартай хүргэхэд бэрхшээл үүсгэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Засгийн газрын 311 дугаар тогтоолын дагуу 4.1.5 "Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт;", Төсвийн тухай хуулийн 16.5.6-д дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоолын хавсралт Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 3.3 "Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна" гэсэн заалттай тус тус нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь:

Сувилагчийн орон тоог нөхөх, хүний нөөцийн зохистой бүрдүүлэлт хийх, дотоод хяналтын бодлого, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, орон тоог бүрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, 5 үндсэн дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 68,140.3 мянган төгрөгийн 1 алдааг запруулсан. Аудитаар 6,864,548.0 мянган төгрөгийн 9 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 6,831,588.0 мянган төгрөгийн 8 зөвлөмжийг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагаатай холбоотой 32,960.0 мянган төгрөгийн 1 зөрчил жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын алдаа, зөрчилтэй нэгтгэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	7	2,632,985.6	7	2,632,958.6	100
Зөвлөмж	6	317,677.1	6	317,677.1	100
Нийт дүн	13	2,950,635.7	13	2,950,635.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын үлдэгдэлд өндөр хувь эзэлж байгаа бусад хангамжийн материалын ашиглалт, зарцуулалт, "Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн 6 давхар барилга, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ажилчдын 150 ортой "Хүүхдийн цэцэрлэг"-ийн барилга, НУБХС-ын дэмжлэгтэй Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн Хүчилтөрөгчийн үйлдвэрийн барилгыг гэрээний хугацаанд ашиглалтад оруулсан, орлогоор бүртгэсэн эсэх, ЭМЯ-аас эрх шилжүүлсэн хөрөнгөөр хийгдэх урсгал засварын ажлуудын сонгон шалгаруулалт гүйцэтгэлд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 100,000.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулсан

Залруулсан алдаа:

- Тайлант онд Эрдэнэс таван толгой ХХК-аас "Нийгмийн хариуцлагын хүрээнд" 100,000.0 мянган төгрөгийн зарцуулалт нь тодорхой бус орлого хүлээн авч урьдчилж орсон орлогоор бүртгээгүй;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Аудитаар нийт 2,108,262.0 мянган төгрөгийн 16 зөрчил² илэрснээс, 1,496,691.9 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 611,570.1 мянган төгрөгийн 12 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,108,262.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материалаг байдлын түвшнээс 1,170,783.1 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд амны хаалт, стандарт фильтер, нярайн малгай, урсгалын сенсор, нүүрний хамгаалалт, үр шилжүүлэн суулгах гуурс зэрэг нийт 49,964 ширхэг, 134,262.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн эхний үлдэгдлээс зарцуулаагүй бөгөөд он дамжуулан үлдэгдлээр бүртгэснээр хэрэгцээ шаардлагагүй нөөц үүссэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "нягтлан бодох бүртгэл үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянах шаардлагатай" гэсэн заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бодит хэрэгцээнд тулгуурлан бүрдүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. ЭХЭМҮТ-ийн ерөнхий захирлын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/121 тоот тушаалаар 93,008.7 мянган төгрөгийн хангамжийн материалыг данснаас хасахаар шийдвэрлэснээс 25,028.9 мянган төгрөгөөр илүү материал данснаас хассан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байна. Энэ нь УСНББОУС-12 "Бараа материал" стандартад заасан бараа материалын бүртгэлийн зарчим болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13.1-т "анхан шатны баримт нь санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болох", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянах үүрэгтэй" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг үнэн зөв үйлдэж, хангамжийн материалын данснаас хасах үйл ажиллагаанд хяналтыг сайжруулах, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3. Тайлант онд НҮБ-ийн Хүн амын сангийн хөрөнгө оруулалтаар "Зүрх судасны мэс заслын тасгийн хагалгааны өрөөнүүдийг вакум нээлттэй мэс заслын өрөө болгон засварлах, тохижуулах түлхүүр гардуулах" нөхцөлтэй тендерт гүйцэтгэгч Би Эм Си Эм ХХК нь шалгарсан. Гэвч тус компани тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан "нийгмийн даатгалын сүүлийн 6 сарын НД-8 маягтын хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлэх" гэсэн шаардлагыг хангаагүй байхад тендерт шалгаруулж, гэрээ байгуулсан байна. Мөн гэрээний нөхцөлд засварын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дуусгахаар заасан боловч гүйцэтгэгч компани засварын ажлыг хугацаанд нь дуусгаагүй тул гэрээг сунгасан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.9-т "Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Тендер шалгаруулалтыг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулаагүй, шаардлага хангаагүй тендерийг шалгаруулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д заасны дагуу 140,400.0 мянган төгрөгийн 2 худалдан авалтыг 3 багцаар шууд худалдан авалт хийсэн байна. Энэ худалдан авалт нь хуульд заасны дагуу хэрэгжүүлэгдээгүй бөгөөд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" заалт болон Засгийн газрын 2024 оны 02 тогтоолтой нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг хуульд нийцүүлэн зохион байгуулах, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дансны буруу бичилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд цалингийн зардлыг 272,033.5 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардлыг 1,005.8 мянган төгрөг, эмийн зардлыг 32,585.0 мянган төгрөг, төлбөр хураамжийн зардлыг 14,220.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 240.0 мянган төгрөг, нийт 320,084.3 мянган төгрөгөөр бууруулж дансны буруу бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Зардлын дансыг бууруулж бичилт хийхгүй байх, бүртгэлийг стандарт, журамд нийцүүлэн хөтөлж, тайлан гаргах.

2. Эм, эмийн хэрэгслийн үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Эм зүйчдийн ашигладаг "Орион" программын эм, эмийн хэрэгслийн үлдэгдлийг санхүүгийн программаар тайлагнасан үлдэгдэлтэй тулгахад Цефапим 1гр 400ш, хавдрын 9 дугаар фактор 500 (ОУН) 28ш, Метотрексат 2,5 мг 495 ш нийт 923ш буюу 29,262.4 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг сайжруулж, эм, эмийн хэрэгслийн үлдэгдлийг үнэн зөв хөтөлж тайлагнах.

3. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2024 онд хийсвэр хагалгааны иж бүрдэл 3,517 ширхгийг зарлагадсан, ЭМДСангаас 2,451 ширхэг хийсвэр хагалгааны дүнг нэхэмжилсэн, 1,066 ширхэг буюу 58,630.0 мянган төгрөгийн хагалгааны иж бүрдэл зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Хагалгааны иж бүрдэл болон зардлыг үнэн зөв, хуулийн дагуу бүртгэж тайлагнах.

4. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 заасан бүрэлдэхүүний дагуу гаргаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-т "тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/", 54.5.2-т "татварын зарлагыг хуулийн этгээд, салбар бүрээр, холбогдох эрх зүйн үндэслэлийн хамт", 54.5.3-т "тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл", 54.5.4-т "хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/", 54.5.5-т "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн бүрэлдэхүүний дагуу тайлагнах.

5. Үргүйдэл нөхөн үржихүйн төвийн орлогын зөрүүтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны Үргүйдэл нөхөн үржихүйн төвийн шинжилгээний болон ажилбарын орлогыг түүвэр хийж дахин тооцоолон, анхан шатны баримттай тулган шалгахад тайлагнасан дүнгээс 21,657.8 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бodoх бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бodoх бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бodoх бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Орлогын тооцооллыг нягтлан бodoх бүртгэлийн аккруэл суурийн зарчимд үндэслэн үнэн зөв хийж, тайлагнах.

6. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс шилжүүлсэн зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс шилжүүлсэн 109,304.3 мянган төгрөгийг "БНХАУ-д суралцах эмч нарын байр хоол замын зардал" гүйлгээний утгаар бүртгэсэн бөгөөд эрх бүхий албан тушаалтны хөрөнгө хуваарилсан шийдвэр байхгүй байна. Энэ нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайландаа тусгахыг хориглоно.", 20.2.4-д "нягтлан бodoх бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэл бүрэн ажил гүйлгээг бүртгэх, эрх бүхий албан тушаалтны хөрөнгө хуваарилсан шийдвэрийг хуулийн дагуу гаргуулах.

7. ЭМДЕГ-ын чанарын болон төлбөрийн хяналтаар тавигдсан хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЭМДЕГ-ын чанарын болон төлбөрийн хяналтаар тус төвийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс цахим хяналтын хасагдал 1,100,761.2 мянган төгрөг, эмчийн болон эх олонлогийн түүврийн хасагдал 2,755,399.3 мянган төгрөг гарч, нийт 3,856,160.5 мянган төгрөг буюу 7.4 хувийн санхүүжилт хасагдсан

**Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

байна. Эм эмнэлгийн үйлчилгээний тайлан болон нэхэмжлэгдсэн санхүүжилт нь нягтлан бодох бүртгэлд бүртгэгдэж, санхүүгийн тайланд тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Баримтын бүрдүүлэлт болон цахим хяналтыг сайжруулж, хасагдсан санхүүжилтийг нягтлан бодох бүртгэлд зөв бүртгэж тайлагнах.

8. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын тайлан болон нийгмийн даатгалын шимтгэлийн дутуу тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2024 оны "Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын тайлан" дахь даатгуулагчаас суутгасан "Эрүүл мэнд болон нийгмийн даатгалын шимтгэл"-ийн дүн, нийгмийн даатгалын тайлангаарх даатгуулагчийн төлөх НДШ-ийн дүнгээс 3,576.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын шимтгэлийг зөв дүнгээр, хуульд заасан шаардлагад нийцүүлэн бүртгэн, тайлагнах.

9. Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зөрүүтэй тайлант асуудал

Илрүүлэлт: Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн дүн нь нийгмийн даатгалын тайлангаар 4,407,527.8 мянган төгрөг байсан боловч Санхүүгийн үр дүнгийн тайлангаар 4,382,501.1 мянган төгрөгөөр тайлагдсан байна. Үүний үр дүнд 25,026.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн дүнг зөв бүртгэн, зөрүүгүй тайлан гаргах.

10. Хуулиар тайлагнах бусад тайлангуудтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайлангаар даатгуулагчаас суутгасан НДШ-ийн дүн 3,868,032.4 мянган төгрөг байсан бол ХХОАТ-ын тайлангаар 3,879,100.5 мянган төгрөг буюу 11,068.1 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба

төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тайлан болон ХХОАТ-ын тайлангийн гүйлгээг зөв хянаж, бүртгэлийг бодитой, зөрүүгүй тайлагнах.

11. Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд хог хаягдлын төлбөрт 32,960.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд тендер сонгон шалгаруулалт явуулаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" заалт болон Засгийн газрын 2024 оны 02 тогтоолтой нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж ажиллах.

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдүүлэлт болон баримт бичгийн архивын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус эмнэлэг нь эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, бодис, өндөр өртөгтэй эмийн худалдан авалтыг нийт 183 багцад хувааж, 12.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр нэг төсөл арга хэмжээ болгон худалдан авалтыг зохион байгуулсан байна. Энэ үйл ажиллагаа нь 5 удаагийн тендер шалгаруулалтаар 2024 оны 3 дугаар сараас 12 дугаар сарын хугацаанд явагджээ. Гэвч худалдан авах ажиллагааг хэрэгжүүлсэн баримтад тендерийн баримт бичиг боловсруулалттай холбоотой хурлын тэмдэглэл байхгүй бөгөөд тус баримтыг архивд хадгалаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-т "Захиалагч худалдан авах ажиллагаа зохион байгуулах бүрд тендер шалгаруулалтын хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараах баримт бичгийг хавсаргана:", 48.5-д "Тендер шалгаруулалтын хувийн хэргийг архивын нэгж болгон хадгална" болон Төрийн аудитын тухай хуулийн 16.1.4-т "Төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тендер шалгаруулалтын баримт бичгийг зохих шаардлагын дагуу бүрдүүлж, хурлын тэмдэглэл болон бусад чухал баримтуудыг архивын бүрдэлд бүрэн хадгалах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	
Тайлант онд Эрдэнэс таван толгой ХХК-аас "Нийгмийн хариуцлагын хүрээнд" 100,000.0 мянган төгрөгийн орлого оруулсаныг юунд зарцуулалт нь тодорхойгүй тул урьдчилж орсон орлогоор буртгэх	1	100,000.0	-	-	1	100,000.0	1	100,000.0	-	-	-	-	
Дүн	1	100,000.0	-	-	1	100,000.0	1	100,000.0	-	-	-	-	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн	Toо	Дүн
	Tайлант хугацаанд цалингийн зардлыг 272,033.5 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардлыг 1,005.8 мянган төгрөг, эмийн зардлыг 32,585.0 мянган төгрөг, төлбөр хураамжийн зардлыг 14,220.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 240.0 мянган төгрөг, нийт 320,084.3 мянган төгрөгөөр бууруулж дансны буруу бичилт хийсэн.	1	320,084.3	-	-	-	-	1	320,084.3	-	-	-
Эм зүйчдийн ашигладаг "Орион" програмын эм, эмийн хэрэгслийн үлдэгдлийг, санхүүгийн программаар тайлагнасан үлдэгдэлтэй тулгахад Цефапим 1гр 400ш, хавдрын 9-р фактор 500 (ОУН) 28ш, Метотрексат 2,5 мг 495 ш нийт 923 ш буюу 29,262.4 мянган төгрөгийн эмийн үлдэгдэл дутуу байна.	1	29,262.4	-	-	-	-	1	29,262.4	-	-	-	-
2024 онд хийсвэр хагалгааны иж бүрдэл 3,517 ширхэг зарлагадсан ЭМДСангаас 2,451 эхийн кесар хагалгааны (кесарево) дүнг нэхэмжилсэн нь 1,066 ширхэг буюу 58,630.0 мянган төгрөгийн хагалгааны иж бүрдэл дутуу зарлагдан байна.	1	58,630.0	-	-	-	-	1	58,630.0	-	-	-	-

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн гүйцэтгэлийн тайлант Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 заасан бүрэлдэхүүний дагуу гаргаагүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тайлант оны Үргүйдэл нөхөн үржихүйн төвийн шинжилгээний болон ажилбарын орлогыг түүвэр хийж дахин тооцооллон, анхан шатны баримттай тулган шалгахад тайлагнасан дүнгээс 21,657.8 мянган төгрөгөөр дутуу зэрүүтэй байна.	1	21,657.8	-	-	-	-	-	1	21,657.8	-	-	-	-
Тайлант онд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс шилжүүлсэн 109,304.3 мянган төгрөгийг "БНХАУ-д суралцах эмч нарын байр хоол замын зардал" гүйлгээний утгаар бүртгэсэн бөгөөд эрх бүхий албан тушаалтны хөрөнгө хуваарилсан шийдвэр байхгүй байна.	1	109,304.3	-	-	-	-	-	1	109,304.3	-	-	-	-
ЭМДЕГ-ын чанарын болон төлбөрийн хяналтаар тус төвийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс /цахим хяналтын хасагдал 1,100,761.2 мянган төгрөг, эмчийн болон эх олонлогийн түүврийн хасагдал 2,755,399.3 мянган төгрөг/ шалтгаалан ЭМДС-аас авах санхүүжилтийг нэхэмжилсэн дүнгээс 3,856,160.5 мянган төгрөг буюу 7.4 хувийн санхүүжилт хасагдсан бөгөөд нягтлан бодох бүртгэлд бүртгэж, санхүүгийн тайланда тайлагнахгүй байна.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2024 оны "Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварын тайлан" дахь даатгуулагчаас суутгасан "Эрүүл мэнд болон нийгмийн даатгалын шимтгэл"-ийн дүн, нийгмийн даатгалын тайлангаарх даатгуулагчийн төлөх НДШ-ийн дүнгээс 3,576.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	3,576.5	-	-	-	-	1	3,576.5	-	-	-	-
Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг нийгмийн даатгалын тайлангаар 4,407,527.8 мянган төгрөг байхад Санхүүгийн үр дүнгийн тайлангаар ажил олгогчийн төлөх дүн, 4,382,501.1 мянган төгрөгөөр тайлагнаж, 25,026.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.	1	25,026.7	-	-	-	-	1	25,026.7	-	-	-	-
Нийгмийн даатгалын тайлангаарх даатгуулагчаас суутгасан НДШ 3,868,032.4 мянган төгрөг ХХОАТ-ын тайлангаар 3,879,100.5 мянган төгрөг буюу 11,068.1 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	11,068.1	-	-	-	-	1	11,068.1	-	-	-	-
Тайлант хугацаанд хог хаягдлын төлбөрт 32,960.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд тендер сонгон шалгаруулалт явуулаагүй байна.	1	32,960.0	-	-	-	-	1	32,960.0	-	-	-	-

01
терийн аудитын багц улсын
ХЯЗГААРЛАЛТЫН
САИЛДЛЫН ЕМЖ

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>Тус эмнэлэг нь эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, бодис, өндөр өртөгтэй эмийн худалдан авалтыг нийт 183 багцад хувааж 12.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр нэг төсөл арга хэмжээ болгон худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Энэхүү үйл ажиллагаа нь 5 удаагийн тендер шалгаруулалтаар буюу 2024 оны 3 дугаар сараас 12 дугаар сарын хугацаанд явагджээ. Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлсэн баримтад тендерийн баримт бичиг боловсруулалттай холбоотой хурлын тэмдэглэл байхгүй байна. Дээрх асуудлыг тусгай үнэлгээний хороогоор хэрэгжүүлсэн гэх боловч архивын бүрдэл болсон баримт бичгийг аудитын явцад ирүүлээгүй болно.</p>	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
<p>Амны хаалт, стандарт фильтер, нярайн малгай, ургсалын сенсор, нүүрний хамгаалалт, үр шилжүүлэн суулгах гуурс зэрэг нийт 49,964 ширхэг 134,262.8 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийн эхний үлдэгдлээс тайлант онд зарцуулаагүй он дамжуулан үлдэгдлээр бүртгэж, хэрэгцээ шаардлагагүй эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц үүссэн.</p>	1	134,262.8	-	-	1	134,262.8	-	-	-	-	-	-	-
<p>ЭХЭМҮТ-ийн ерөнхий захирлын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/121 тоот тушаалаар 93,008.7 мянган төгрөгийн хангамжийн материал данснаас хасахаар шийдвэрлэснээс 25,028.9 мянган төгрөгээр илүү материал данснаас хассан.</p>	1	25,028.9	-	-	1	25,028.9	-	-	-	-	-	-	-

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

01 ХЭЗГААРДЛЫН СИЛАЛ ДҮГНЭЛТ <small>ТЕРИЙН АУДИТИН БАЛГУУЛАЛАА</small>	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <tbody> <tr> <td style="padding: 5px;">Тайлант онд НҮБ-ийн Хүн амын сангийн хөрөнгө оруулалтаар "Зүрх судасны мэс заслын тасгийн хагалгааны өрөөнүүдийг вакум нээлттэй мэс заслын өрөө болтон засварлах, тохижуулах түлхүүр гардуулах" нөхцөлтэй тендert гүйцэтгэгч Би Эм Си Эм ХХК нь тендерийн өгөгдлийн хүснэгтэнд ирүүлэхийг шаардсан "нийгмийн даатгалын сүүлийн 6 сарын НД-8 маягтын хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ" гэсэн баримт бичгийг ирүүлээгүй байхад тендert шалгаруулан гэрээ байгуулсан байна. Гэрээний нөхцөлд засварын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дуусахаар заасан боловч засварын ажлыг дуусгаагүй гэрээ сунгасан байна.</td><td style="padding: 5px; text-align: right;">1</td><td style="padding: 5px; text-align: right;">1,197,000.2</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: right;">1</td><td style="padding: 5px; text-align: right;">1,197,000.2</td><td style="padding: 5px; text-align: right;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td></tr> <tr> <td style="padding: 5px;">Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д заасны дагуу гэрээ 140,400.0 мянган төгрөгийн 2 худалдан авалтыг 3 багцаар шууд худалдан авалт хийсэн байна. Тус худалдан авалтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлээгүй бөгөөд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна.</td><td style="padding: 5px; text-align: right;">1</td><td style="padding: 5px; text-align: right;">140,400.0</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: right;">1</td><td style="padding: 5px; text-align: right;">140,400.0</td><td style="padding: 5px; text-align: right;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td></tr> <tr> <td style="padding: 5px;">Дүн</td><td style="padding: 5px; text-align: right;">16</td><td style="padding: 5px; text-align: right;">2,108,262.0</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: right;">4</td><td style="padding: 5px; text-align: right;">1,496,691.9</td><td style="padding: 5px; text-align: right;">12</td><td style="padding: 5px; text-align: right;">611,570.1</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td><td style="padding: 5px; text-align: center;">-</td></tr> </tbody> </table>	Тайлант онд НҮБ-ийн Хүн амын сангийн хөрөнгө оруулалтаар "Зүрх судасны мэс заслын тасгийн хагалгааны өрөөнүүдийг вакум нээлттэй мэс заслын өрөө болтон засварлах, тохижуулах түлхүүр гардуулах" нөхцөлтэй тендert гүйцэтгэгч Би Эм Си Эм ХХК нь тендерийн өгөгдлийн хүснэгтэнд ирүүлэхийг шаардсан "нийгмийн даатгалын сүүлийн 6 сарын НД-8 маягтын хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ" гэсэн баримт бичгийг ирүүлээгүй байхад тендert шалгаруулан гэрээ байгуулсан байна. Гэрээний нөхцөлд засварын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дуусахаар заасан боловч засварын ажлыг дуусгаагүй гэрээ сунгасан байна.	1	1,197,000.2	-	-	1	1,197,000.2	-	-	-	-	-	-	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д заасны дагуу гэрээ 140,400.0 мянган төгрөгийн 2 худалдан авалтыг 3 багцаар шууд худалдан авалт хийсэн байна. Тус худалдан авалтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлээгүй бөгөөд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна.	1	140,400.0	-	-	1	140,400.0	-	-	-	-	-	-	Дүн	16	2,108,262.0	-	-	4	1,496,691.9	12	611,570.1	-	-	-	-
Тайлант онд НҮБ-ийн Хүн амын сангийн хөрөнгө оруулалтаар "Зүрх судасны мэс заслын тасгийн хагалгааны өрөөнүүдийг вакум нээлттэй мэс заслын өрөө болтон засварлах, тохижуулах түлхүүр гардуулах" нөхцөлтэй тендert гүйцэтгэгч Би Эм Си Эм ХХК нь тендерийн өгөгдлийн хүснэгтэнд ирүүлэхийг шаардсан "нийгмийн даатгалын сүүлийн 6 сарын НД-8 маягтын хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ" гэсэн баримт бичгийг ирүүлээгүй байхад тендert шалгаруулан гэрээ байгуулсан байна. Гэрээний нөхцөлд засварын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дуусахаар заасан боловч засварын ажлыг дуусгаагүй гэрээ сунгасан байна.	1	1,197,000.2	-	-	1	1,197,000.2	-	-	-	-	-	-																												
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д заасны дагуу гэрээ 140,400.0 мянган төгрөгийн 2 худалдан авалтыг 3 багцаар шууд худалдан авалт хийсэн байна. Тус худалдан авалтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлээгүй бөгөөд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна.	1	140,400.0	-	-	1	140,400.0	-	-	-	-	-	-																												
Дүн	16	2,108,262.0	-	-	4	1,496,691.9	12	611,570.1	-	-	-	-																												

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага	Зөвлөмж	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Эмнэлгийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд тус эмнэлгийн хамт олны төлөөлөх З гишүүнийг томилуулахаар, Ерөнхий захирлын тушаал гаргаагүй, “Ажлын хэсэг байгуулах тухай” З гишүүнийг сонгох хурал хийгээгүй байна. 2025 оны нэгдүгээр улиралд багтааж ТУЗ байгуулж, төсөв төлөвлөгөө батлуулж холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу ажиллах шаардлагатай байна.	1	-	-	-	1	-
Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтантай бөгөөд санхүүгийн дотоод хяналтын ажилтангүй байна. Мөн тайлант онд санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.	1	-	-	-	1	-
Мэдээллийн аюулгүй байдлыг иж бүрэн хангаж, /холбогдох хуулийг/ хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тус эмнэлгийн мэдээллийг дамжуулж байгаа санхүүгийн болон хүний нөөцийн ажиллагсад албаны цахим хаяг ашиглахгүй байна. Улмаар мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа нь тодорхой бус байна.	1	-	-	-	1	-
Хүний нөөцийн хувьд үйл ажиллагааны онцлогт тохирсон орон тоог зохицойгоор бүрдүүлэх, сувилагчийн орон тоо дутагдалтай байгаа нь үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүргэхэд бэрхшээл бий болгох эрсдэлтэй байна.	1	-	-	-	1	-
Дүн	4	-	-	-	4	-
Нийт дүн	4	-	-	-	4	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 187/АО150185

Улаанбаатар хот

СНАГ-2025/153/ИА-СТА-ПШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх, хуүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Тайлант онд НҮБ-ын Хүн амын сангийн хөрөнгө оруулалтаар "Зурх судасны мэс заслын тасгийн хагалгааны өрөөнүүдийг вакум нээлттэй мэс заслын өрөө болгон засварлах, тохижуулах түлхүүр гардуулах" нөхцөлтэй тендерт гүйцэтгэгчээр "Би Эм Си Эм" ХХК нь шалгарсан. Гэвч тус компани тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан "нийгмийн даатгалын сүүлийн 6 сарын НД-8 маягтын хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлэх" гэсэн шаардлагыг хангаагүй байхад тендерт шалгаруулж, 1,197,000,000.00 /Нэг тэрбум нэг зуун ерэн долоон сая/ төгрөгийн грээ байгуулсан байна. Мөн гэрээний нөхцөл засварын ажлыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр дуусгахаар заасан боловч гүйцэтгэгч компани засварын ажлыг хугацаанд нь дуусгагүй тул гэрээг сунгасан байна.

Эн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.9-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоо, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн ШААРДАХ нь:

- Тендер шалгаруулалтыг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулаагүй, шаардлага хангаагүй тендерийг шалгаруулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, хуүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал /Ж.Огтонбаатар/, Стратеги хариуцсан дэд захирал /Э.Бямбасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

И.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Д.ЭХБАЯР

ATA9493 4006109
9033230583

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264210

Z: Alban Shaardlaga 2025/0225 SNAG-18.Docx

1525300413



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 184/A0150185

Улаанбаатар хот

СНАГ-2025/152/ИА-СТА-ТШ3

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 140,400,000.00 /Нэг зуун дөчин сая дөрөвөн зуун мянган/ төгрөгийн 2 худалдан авалтыг 3 багцаар хувааж шууд худалдан авалт хийсэн байна. Энэ худалдан авалтыг хуульд заасны дагуу хэрэгжүүлэгдээгүй бөгөөд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт гэрээ байгуулснаас хойш ажлын 10 өдрийн дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 24 дүгээр зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан Үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоо, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-д заасан нөхцөл үүсээгүй бол" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Худалдан авалтыг хуульд нийцүүлэн зохион байгуулах, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал /Ж.Онгонбаатар/, Стратеги хариуцсан дэд захирал /Э.Бямбасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР / : ЦНАРАНЧИМЭГ
АУДИТИН МЕНЕЖЕР / : В.ЭРДЭНЭЦОГТ
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭС ЖИ ИМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ / : Д.ЭХБАЯР

АТА9693 9006109
9073030583

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z: Albanshaardлага 2025/0225 SNAG-18.Docx

1525900415



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 185/A0150185

Улаанбаатар хот

СНАГ-2025/152/ИА-СТА-ТШ3

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аudit хийх явцад дараах зөрчил илрэлзээ.

Тайлант хугацаанд амны хаалт, стандарт фильтер, нярайн малгай, ургалын сенсор, нүүрний хамгаалалт, үр шилжүүлэн суулгах гуурс зэрэг нийт 49,964 ширхэг, 134,262,800.00 /нэг зуун гучин дөрвөн сая хоёр зуун жаран хоёр мянга найман зуу/ төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн эхний үлдэгдлээс зарцуулаагүй бөгөөд он дамжуулан үлдэгдлээр бүртгэснээр хэрэгцээ шаардлагагүй нөөц үүссэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "нягтлан бодох бүртгэл үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага егнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бодит хэрэгцээнд тулгуурлан бүрдүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал /Ж.Олонбаатар/, стратеги хариуцсан дэд захирал /Э.Бямбасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:

ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

В.ЭРДЭНЭЦОГТ

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardлага\2025\0225\SNAG-18.Docx

ATA9693 7006189
9023030583

1525300439



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 186/А0150185

Улаанбаатар хот

СНАГ-2025/153/ИА-СТА-ПШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирлын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/121 тоот тушаалаар 93,008,700.00 /ерэн гурван сая найман мянга долоон зуун/ төгрөгийн хангамжийн материалыг данснаас хасахаар шийдвэрлэснээс 25,028,900.00 /Хорин таван сая хорин найман мянга есөн зуун/ төгрөгөөр илүү материал данснаас хассан байна.

Энэ нь УСНББОУС-12 "Бараа материал" стандартад заасан бараа материалын бүртгэлийн зарчим болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13.1-д "анхан шатны баримт нь санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болох", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянах үүрэгтэй" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Анхан шатны баримтыг үнэн зөв үйлдэж, хангамжийн материалын данснаас хасах үйл ажиллагаанд хяналтыг сайжруулах, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал /Ж.Огтонбаатар/, Стратеги хариуцсан дэд захирал /Э.Бямбасүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Д.ЭХБАЯР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 12 хороо, Бага тойруу-3,
Утас 51-264230

Засгийн газрын 4 дүгээр байр,

АТА9543 9006109
9023030583

Z: Alban Shaardлага/2025/0225 SNAG-18.Docx

1525300411

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn
Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс